



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БОДЛОГЫН ОРЧИН

Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилгыг нутагшуулах ажил үргэлжилж байна.

Монгол Улсын Их Хурлаас “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-ийг 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталсан. Монгол Улс ийнхүү анх удаа бодлого төлөвлөлтийн тодорхой хуультай болсон нь 1990 оноос хойш хэрэгжиж ирсэн бодлого төлөвлөлтийн үйл явцыг цэгцэлж, хөгжлийн бодлогыг иргэн, өрх гэр, ажахуйн нэгж бүрд хүрсэн, үндэсний хэмжээнд тууштай, үр дүнтэй, хүртээмжтэй хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тавилаа. УИХ-аас МУТХҮБ-2030 хэмээх урт хугацааны хөгжлийн бодлогыг “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-ийг үндэслэн 2016 онд баталсан нь ТХЗ-ыг үндэсний бодлогод нийцүүлж нутагшуулж эхэлсэн томоохон алхам болсон. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг тогтвортой хөгжлийн тулгуур

зарчим болох эдийн засаг, нийгэм, байгаль, орчны харилцан хамаарлыг эрхэмлэсэн цогц бодлого болгохыг зорьсон юм.

Тогтвортой хөгжлийн зорилгыг хангах институцын тогтолцоог бэхжүүлэх нь

Монгол Улс хөгжлийн бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийн зохицуулалтыг хангах, институцын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэх үндэсний зохион байгуулалтын бүтцийг төрийн өндөр түвшинд бүрдүүлсэн:

- Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэргэдэх **Тогтвортой хөгжлийн Дэд хороо**

- Ерөнхий сайдын ахалсан Тогтвортой хөгжлийн **Үндэсний хороо**

-ТХЗ-ыг урт, дунд, богино хугацааны бодлогод тусган, уялдаа, зохицуулалттай хэрэгжүүлэхэд Засгийн газарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий **Үндэсний хөгжлийн газар**

-ТХЗ-ын хэрэгжилтийг хянах, тоо мэдээллийг бүрдүүлэх үүрэг бүхий **Үндэсний статистикийн хороо**

Монгол Улс “төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх”, “олон нийтийн оролцоог хангасан цогц байх” зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хөгжлийн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй, нэгдмэл цогц, олон талын оролцоог хангаж

Зураг. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг ТХЗ-д нийцүүлэх замын зураглал





ҮНДЭСНИЙ САЙН ДУРЫН ИЛТГЭЛ 2019

Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт



боловсруулах, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

Одоогоор 200 гаруй бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа боловч ихэнх нь “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-д нийцэхгүй байна.

Засгийн газраас бодлогын уялдаа холбоог хангах, зорилтот түвшинг тогтоох аргачлалыг боловсруулж, “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-ийг дагаж гарсан нийтлэг журамд 2018 оны 294 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 2 дугаар захирамжаар ТХЗ болон урт хугацааны бодлого, тэдгээрийн хоорондын уялдааг хангах хүрээнд 1990 оноос хойших одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн хоорондын уялдаагүнэлэх ажлын хэсгийг байгуулж, ЗГХЭГ нэгдсэн удирдлагаар, ҮХГ мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллаж байна. Тус ажлын үр дүнд, бодлогын баримт бичгүүдэд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах юм.

Хөгжлийн санхүүжилтийг тогтвортой хөгжилд чиглүүлэх нь

Монгол Улс 2018 онд Хөгжлийн санхүүжилтийн үнэлгээг санаачлан хийсэн бөгөөд уг үнэлгээнд цаашид урт хугацааны хөгжлийн зорилтыг хангахын тулд санхүүгийн өргөн хүрээний нэгдсэн удирдлагыг бий болгоход чиглэсэн Үндэсний санхүүжилтийн нэгдсэн хүрээ (ҮСНХ)-г нэвтрүүлэхийг зөвлөмж болгосон юм. Бодлого, хөтөлбөрийн ангилал болон төсвийг ТХЗ- той уялдуулах үндсэн чиглэлийг эрүүл мэндийн салбарын жишээ дээр харуулсан болно.

Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийн үр дүнг хянах, үнэлэх, тайлагнах тогтолцоог бүрдүүлж байна.

МУТХҮБ-2030-ын хэрэгжилтийн хоёр жил тутмын үнэлгээ нь ТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх тогтолцооны суурь болж байна. Гэвч ТХЗ- ын шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг үндэсний хэмжээнд тодорхойлохгүйгээр хэрэгжилт, үр дүнг үнэлэх боломжгүй байна.

ЗГХЭГ-ын даргын 2019 оны 29 дүгээр тушаалаар олон талын оролцоотой 8 дэд ажлын хэсгийг байгуулж, ТХЗ-ын үндэсний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлох ажлыг хийж байна. Энэ нь ТХЗ-ын хэрэгжилтийг үр дүнд

ҮЗҮҮЛЭЛТ	Үнэлгээ хийсэн хугацаа (он сар)			
	2015.11	2016.3	2017.10	2018.12
Монгол Улсад хамаарахгүй	13	13	11	11
Бэлэн	45	60	113	118
Нэмэлт тооцоолол шаардлагатай	92	11	0	0
Бэлэн бус	43	157	120	115
Үнэлгээ хийсэн нийт үзүүлэлт	224	241	244	244

Эх сурвалж: YCX 2019, www.sdg.gov.mn

тулгуурлан хянах ажлын эхлэл юм.

ТХЗ-ын тоон мэдээлэл нь албан ёсны болон захиргааны статистикаас бүрдэж байгаа бөгөөд цаашид ТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэхдээ үр дүнг нь тооцож болохуйц судалгаа, шинжилгээ, төрийн бус байгууллага, гео орон зайн мэдээ, мэдээлэл зэрэг шинэ эх үүсвэрийг ашиглах шаардлагатай байна.

Олон талын оролцоо, түншлэлийг Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын дагуу хөгжүүлэх нь.

Хөгжлийн үйл явцад бүх талын оролцоог хангах байнгын механизмыг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой юм. ТХЗ-ын өргөн цар хүрээний, үндэсний түвшний асуудал болох талаар нэгдмэл ойлголтод хүрэх нь нэн чухал байна. ТХЗ-ын хэрэгжилт орон нутаг, анхан шатны нэгжид явуулж байгаа үйл ажиллагаанаас ихээхэн хамаарах учир орон нутгийн засаг захиргаа, төрийн болон бусад өмчийн аж ахуйн нэгж байгууллагыг ч мөн адил нэгдмэл ойлголттой болгох, татан оролцуулах нь зүйтэй юм. Иймд, хөгжлийн явцад олон талын оролцоог хангах тогтолцоог бий болгох шаардлагатай.

Холбоо барих:

Үндэсний хөгжлийн газар

Монгол Улс, Улаанбаатар хот 151610,

Чингэлтэй дүүрэг,

Нэгдсэн Үндэстний гудамж 5/1

Утас: (976) 51-263333

И-мэйл: info@nda.gov.mn

Вэб сайт: www.nda.gov.mn



Scan me



MONGOLIA'S SUSTAINABLE DEVELOPMENT ENABLING POLICY ENVIRONMENT

Work on localizing the sustainable development goals is underway. The State Great Khural (Parliament) adopted the Law on Development Policy and Planning on 26 November of 2015. This law is the legal basis for establishing an integrated system of development policy and planning. The adoption of this law enabled policy-makers to re-assess and systemize the process of policy planning for the first time since the 1990s. Following this, the adoption of the Mongolia's Sustainable Development Vision-2030 (MSDV-2030) in 2016 was an important step towards ensuring SDG localization and alignment of national policies with SDGs. The MSDV-2030 was developed considering the interdependent and comprehensive nature of economic, social and environmental pillars of sustainable development.

Creating Institutional Structures for Sustainable Development


Mongolia is working towards establishing the institutional framework for ensuring policy planning and regulatory mechanisms. Apex level institutional mechanisms have been established:

- Sub-Committee on SDGs under the Standing Committee on Social Policy, Education, Culture and Science of the Parliament
- National Council for Sustainable Development headed by the Prime Minister
- National Development Agency mandated to provide technical policy support and ensure mainstreaming of the SDGs
- National Statistical Office to strengthen SDG indicators and data collection

The Government of Mongolia recognizes the importance of "whole of government" and "whole of society" approaches

The SDGs require development policies to be holistic, scientifically sound, integrated, and incorporate multi-stakeholder participation.

Figure. Roadmap for Aligning Mongolia's Long Development Policy with the SDGs





Currently, there are over 200 effective policy documents, and a majority of them are not compliant with the Law on Development Policy and Planning. Consequently, these documents have tended to be marked by duplication, contradictions, and gaps.

Tools on assessing policy coherence have been developed and adopted by Government Resolution No. 294. A Working Group including all state organizations with a mandate to formulate policies was established by the Prime Minister's Order No. 2 of 2019 and using this tool, a systematic review was undertaken to assess the alignment of existing policies with the SDGs, and country's long and medium-term development policies. Based on results of the review, necessary adjustments will be made to align policies with the SDGs.

Directing Development Financing Towards Sustainable Development

Mongolia initiated the process of Development Finance Assessment in 2018. In the future, Mongolia needs to develop an Integrated National Financing Framework (INFF) for setting up a broadbased integrated management system that ensures consistency between planning and budgeting processes to support the achievement of future long-term development. The example of the health sector provides forward-looking directions for strengthening the alignment between policies, program classification and budgets with the SDGs.

SDG progress monitoring, evaluation and reporting system is established. The review of MSDV-2030 on a two-yearly basis is the foundation for the monitoring and evaluation of SDG implementation. However, it is impossible to assess SDG progress without approved national level SDG targets and indicators.

To address these challenges, eight Sub-Working Groups were established to identify national SDG indicators and targets by the Chief of the Cabinet Secretariat's Decree No. 29 of 2019. This process sets the foundation for results-based monitoring of SDG targets and indicators. In addition, the

INDICATORS	Review date (year, month)			
	NOV.2015	MAR 2016	OCT 2017	DEC 2018
Not Applicable to Mongolia	13	13	11	11
Readily available	45	60	113	118
Available after additional estimation	92	11	0	0
Not available	43	157	120	115
Total number of global SDG indicators reviewed	224	241	244	244

Source: NSO, 2019, www.sdg.gov.mn

National Statistical Office has conducted four readiness assessments on against the global SDG indicators.

At the present, the two main data sources are official statistics by the NSO and administrative records from ministries. It is necessary to broaden the data sources by including new information sources such as information from academia, research institutes, NGOs and geo-spatial data for tracking SDG progress.

Building Multi-stakeholder Participation and Partnership, while "leaving no one behind". Participation is required at all levels of government. Reaching a common understanding on the broader scope of the SDGs and recognize that the SDGs are not just national-level responsibilities. Local participation is key, as SDG implementation will largely depend on activities to be carried out locally. Taking this into consideration, it is important to establish a permanent mechanism to ensure participation in the development process.

Contact address:
National Development Agency
United Nations Street 5/1
Ulaanbaatar 15160, Mongolia
Telephone: (976) 51-263333
Email: info@nda.gov.mn
Website: www.nda.gov.mn

